



## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 45

Есөнбулаг сум

### Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж, удирдамж чиглэлээр хангаж, хэрэгжилтийг жил бүрийн эцэст ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн “Журам батлах тухай” 2014 оны 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оныг 03 дугаар  
сарын 1-ны өдрийн 1/ тогтоолын 1  
дүгээр хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР  
ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгж байгууллагад олгох, хугацаа сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр энэ журмаар зохицуулна.

Хоёр. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

2.1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл; /маягтын дагуу үнэн, зөв, тодорхой бөглөсөн байна/

2.2. Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ;

2.3. Сум, багийн Засаг даргын санал;

2.4. Цагдаагийн газрын тодорхойлолт

2.5. Татварын хэлтсийн тодорхойлолт;

2.6. Гадна, дотно тохижилтын зураг;

2.7. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /тусгай зөвшөөрөл хүссэн материал хүлээн авах мэргэжилтэн зөвшөөрсөн тохиолдол/.

Гурав. Тусгай зөвшөөрөлтэй газруудад тавигдах шаардлага

3.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна.

3.1.1. Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт бүртгүүлж, дүгнэлт гаргуулсан байх;

3.1.2. Үйл ажиллагааны төрлөөс хамаарч “Худалдааны үйлчилгээ, Худалдааны байгууллагын ангилал, тодорхойлолт MNS 6506:2015”, “Худалдааны газар, түүний үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946:2005” стандартын шаардлагыг 90-ээс дээш хувь хангасан байх;

3.1.3. Сумын Засаг даргын Тамгын газартай тохижилт, хог хаягдлын гэрээ байгуулсан байх;

3.1.4. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан байх;

3.1.5. Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэж, хэрэглэгчдэд E баримт олгодог байх;

3.1.6. Худалдаа үйлчилгээний газар нь хэрэглээний болон ил тод байдлын нөхцөлийг хангасан /барааны байршил тасгаар заасан таних тэмдэг, бүдүүвч зураглал, барааны үнийг нэг бүрчлэн үнэн зөв, ил тод бичиж байрлуулсан/ байх;

3.1.7. Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналтын телекамерийн системтэй, анхааруулга, сэрэмжлүүлэг зэргийг байршуулсан мэдээллийн самбар, гадна болон дотор талд гэрэлтүүлэг хийсэн байх; /үүдний хэсэгт халтиргаа, гулгаанаас хамгаалсан шалавчтай/

#### Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгох

4.1. Аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ холбогдох материалын хамт /шинээр олгох, сунгах/ аймгийн Засаг даргад гаргана.

4.2. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.2. Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон энэ журамд заасан шаардлагыг хангасан аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын шийдвэрээр хоёр жилийн хугацаагаар олгож, хоёр жилийн хугацаагаар сунгана.

4.3. Нэг объектод үйл ажиллагаа явуулж байгаа газруудад стандартад заагдсан ангиллын дагуу тус тусдаа тусгай зөвшөөрөл олгогдоно.

4.4. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг ажлын 3 өдөрт багтаан сумын Засаг дарга, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэст хүргэж аймгийн вэб сайтад байршуулна.

4.5. Улирлын чанартай үйлчилгээ болон шаардлагатай тохиолдолд олон нийтийг хамарсан арга хэмжээнд спиртийн сул агууламжтай согтууруулах ундааны зөвшөөрлийг түр хугацаагаар журамд заасны дагуу олгож болно.

#### Тав.Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах

5.1. Дараах тохиолдолд тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

5.1.1. Энэхүү журамд заасан шаардлагыг хангахгүй тохиолдолд;

5.1.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас удаа дараа гомдол гаргасан, тэр нь үндэслэлтэй болох нь тогтоогдсон;

#### Зургаа. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

6.1. Тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд түдгэлзүүлэх шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

6.1.1 Татварын хэлтэст татвар суутгагчаар бүртгүүлээгүй, суутгасан татварын тооцоо хийгээгүй;

6.1.2. Тусгай зөвшөөрөл олгогдсоноос хойш 1 сарын хугацаанд тусгай зөвшөөрөл хүсэгч тусгай зөвшөөрлөө аваагүй;

6.1.3. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгалтыг хугацаанд нь сунгуулаагүй;

6.1.4. Мэргэжлийн байгууллагуудын албан шаардлагыг биелүүлээгүй тухай санал, дүгнэлт.

6.2. Тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

6.3.Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

Долоо. Тусгай зөвшөөрлийг сунгах

7.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө дараахь материалыг бүрдүүлж тусгай зөвшөөрлийн сунгалтыг хийлгэнэ.

- 7.1.1. Сумын Засаг даргын тодорхойлолт;
- 7.1.2. Цагдаагийн газрын тодорхойлолт;
- 7.1.3. Мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт;
- 7.1.4. Татварын хэлтсийн тодорхойлолт;
- 7.1.5. Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлт;
- 7.1.6. Иргэн, хуулийн этгээдийн бичиг баримтын хуулбар
- 7.1.7. Тусгай зөвшөөрлийн хуулбар хувь.

7.2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

Найм. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

8.1.Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага нь дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

- 8.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
- 8.1.2.хуулийн этгээд татан буугдсан;
- 8.1.3.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 8.1.4. хууль тогтоомж, дүрэм журам, стандартын шаардлагыг хангаагүй, энэ журам болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг 2 буюу түүнээс дээш удаа зөрчсөн тухай цагдаа, мэргэжлийн хяналт, татварын байгууллагаас мэдэгдэж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар санал ирүүлсэн нь үндэслэлтэй.

Ес. Хяналт

9.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд сум, багийн Засаг дарга, цагдаа, мэргэжлийн хяналт, татварын байгууллагууд хяналт тавина.

9.2. Тусгай зөвшөөрөлтэй газруудад холбогдох мэргэжлийн байгууллагууд чиглэлийн болон төлөвлөгөөт хяналт шалгалт хийж гарсан зөрчлийн талаарх санал, дүгнэлтээ аймгийн Засаг даргад ирүүлж тодорхой шийдвэр гаргуулна.

9.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудыг нэгдсэн арга зүйн удирдлагаар ханган ажиллана.